



ИНД-95

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Хэрэглэлийн нислэгийн журмын бүртгэл

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-95 нь Монгол Улсын нислэгийн мэдээллийн бүсэд хэрэглэлийн нислэгийн дүрэм (ХНД/ IFR)-ээр үйл ажиллагаа явуулах агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журмыг түгээх зохицуулалтын шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-95-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-95, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт

2003 оны 02 сарын 01

Нэмэлт, өөрчлөлт 1

2010 оны 05 сарын 07

Нэмэлт, өөрчлөлт 2 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-95-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 95 A.1-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг — Ерөнхий зүйл.....	5
95.1. Зорилго	5
В Бүлэг — Хэрэглэлийн нислэгийн журмыг түгээх болон мэдэгдэх.....	5
95.51. Хэрэглэлийн нислэгийн журмыг түгээх.....	5
95.53. Монгол Улсын агаарын навигацийн бүртгэлд дэлгэрэнгүйг оруулах	5
95.55. Олон нийтэд мэдэгдэх.....	6
95.57. Хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэглээнээс хураах.....	6

А Бүлэг — Ерөнхий зүйл

95.1. Зорилго

Энэ дүрэм нь Монгол Улсын нислэгийн мэдээллийн район (FIR)-д, Хэрэглэлийн нислэгийн дүрэм (ХНД/IFR)-ээр үйл ажиллагаа явуулах агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журмыг түгээх зохицуулалтын шаардлагыг тогтооно.

В Бүлэг — Хэрэглэлийн нислэгийн журмыг түгээх болон мэдэгдэх

95.51. Хэрэглэлийн нислэгийн журмыг түгээх

(а) Аливаа этгээд нь Монгол Улсын FIR-д, ХНД/IFR-ээр үйл ажиллагаа явуулах агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журмыг дараахаас бусад тохиолдолд түгээхийг хориглоно:

- (1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмын дэлгэрэнгүйг Монгол Улсын Агаарын навигацийн бүртгэл (ANR)-д энэ Дүрмийн дагуу оруулсан;
- (2) тухайн Хэрэглэлийн нислэгийн журмын хүчин төгөлдөр болох огноо нь 95.55-ын дагуу цахим хуудас: www.mcaa.gov.mn-д зарлагдсан.

95.53. Монгол Улсын агаарын навигацийн бүртгэлд дэлгэрэнгүйг оруулах

(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, Дарга Монгол Улсын FIR-д, ХНД/IFR-ээр үйл ажиллагаа явуулах агаарын хөлөгт ашиглахад зориулсан хэрэглэлийн нислэгийн журам бүрийн дараах дэлгэрэнгүйг Монгол Улсын ANR-д оруулах үүрэгтэй:

- (1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмын нэр, эсхүл бусад тохирох таних нэр томъёо;
- (2) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг тодорхойлох болон тайлбарлах нисэхийн өгөгдөл;
- (3) тухайн хэрэглэлийн нислэгийн журам хүчинтэй болох огноо;
- (4) энэ зүйлийн (b)(1)-д шаардсан тухайн Хэрэглэлийн нислэгийн журмыг батлах хариуцлага бүхий хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийн тодорхойлолт;
- (5) энэ зүйлийн (b)(2)-т шаардсан, Хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлт хийх хариуцлага бүхий хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийн тодорхойлолт.

(b) Хэрэглэлийн нислэгийн журмыг тогтоож буй нисэхийн өгөгдлийг Монгол Улсын ANR-д оруулахын өмнө Дарга дараах ажиллагааг бататгах үүрэгтэй:

- (1) ИНД-173-ын дагуу олгосон хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний зохих, хүчинтэй гэрчилгээ эзэмшигчээр зохих ёсоор зөвшөөрөгдсөн этгээд, тухайн хэрэглэлийн нислэгийн журам нь ИНД-173-ын холбогдох шаардлага болон стандартыг хангасан болохыг баталсныг;

- (2) энэ хэсгийн (1)-д дурьдсан зохих, хүчинтэй хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийг төлөөлж буй этгээд, тухайн хэрэглэлийн нислэгийн журам нь ИНД-173.63-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны журмын дагуу засвар өөрчлөлт хийсэн болохыг баталсныг;
- (3) энэ зүйлийн (а)-д шаардсан нисэхийн өгөгдлийн аливаа ажиллагааны, эсхүл боловсруулалтын болон аливаа мэдээлэл оруулах, сэргээх, эсхүл хадгалах үед RTCA Inc-ийн document number RTCA/DO-200A-д заасан ажиллагаа, эсхүл боловсруулалтын стандартыг, эсхүл Даргын хүлээн зөвшөөрсөн дүйцэх бусад стандартыг хангаж байгааг.

(с) Дарга, хэрэглэлийн нислэгийн журамтай холбоотой нисэхийн өгөгдлийг Монгол Улсын ANR-д оруулах, эсхүл гаргах аливаа хөдөлгөөн нь Нисэхийн мэдээлэл дамжуулах стандарт загвар-5 (AIXM-5)-д заасан стандарт, эсхүл дүйцнэ гэж Даргын хүлээн зөвшөөрсөн бусад стандартыг хангаж байгааг бататгах үүрэгтэй.

95.55. Олон нийтэд мэдэгдэх

(а) ХНД/IFR-ээр үйл ажиллагаа явуулах агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журам нь дараахаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр болохгүй:

- (1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмын дэлгэрэнгүйг 95.53-ын дагуу Монгол Улсын ANR-д оруулсан;
- (2) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, Дарга дараах мэдээллийг цахим хуудас: www.mcaa.gov.mn-д зарлан мэдээлсэн:
- (i) тухайн хэрэглэлийн нислэгийн журмын нэр, эсхүл холбогдох бусад таних нэр томъёо;
- (ii) ХНД / IFR-ээр үйл ажиллагаа явуулах агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журмын хүчинтэй болох тухайн огноо.

(b) 6 сар, эсхүл түүнээс бага хугацаагаар хүчинтэй байх хэрэглэлийн нислэгийн журмыг, хэрэв энэ зүйлийн (а)(2)-т шаардсан тухайн мэдээлэл нь Монгол Улсын AIP-д нэмэлтээр, эсхүл NOTAM-аар зарлагдсан бол, цахим хуудас: www.mcaa.gov.mn-д зарлах шаардлагагүй.

95.57. Хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэглээнээс хураах

(а) ИНД-173-ын дагуу олгосон хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээ эзэмшигч нь Монгол Улсын ANR-д орсон аливаа Хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлт хийхээ зогсоохоо зорьж байгаагаа мэдэгдсэн бол, Дарга тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг дараах хэлбэрээр хэрэглээнээс хурааж авах үүрэгтэй:

- (1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг таньж тогтоон, тухайн журам хэрэглээнээс хураагдах огноог цахим хуудас: www.mcaa.gov.mn-д зарлах;
- (2) хураан авах тухайн өдөр нь хэрэглэлийн нислэгийн журмын дэлгэрэнгүйг Монгол Улсын ANR-аас хасах.

(b) Энэ зүйлийн (a)-д заасныг үл харгалзан, хэрэв Дарга дараах бодит үндэслэл байна гэж үзвэл, хамгийн тохиромжтой хэлбэрээр тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг Дарга хэрэглээнээс хураан авч болно:

- (1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг ХНД/IFR-ээр үйл ажиллагаа явуулж буй агаарын хөлөгт ашиглахад аюултай байж болзошгүй; эсхүл
- (2) тухайн хэрэглэлийн нислэгийн журамд ИНД-173-ын холбогдох шаардлагын дагуу засвар өөрчлөлт хийгээгүй.

(c) Хэрэв Дарга энэ зүйлийн (a), эсхүл (b)-ийн дагуу хэрэглэлийн нислэгийн журмыг хэрэглээнээс хураан авах бол:

- (1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг хураан авч байгааг, Монгол Улсын ANR-д заасан, хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлт хийх хариуцлага бүхий хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчид бичгээр мэдэгдэх;
- (2) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг Монгол Улсын AIP-аас болон үйл ажиллагааны хэрэглээнээс хассаныг бататгах зохих арга хэмжээг авах;
- (3) тухайн хэрэглэлийн нислэгийн журам болон түүнтэй холбоотой нисэхийн өгөгдлийг Монгол Улсын ANR-аас хасах үүрэгтэй.

--oOo--